



Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлж буй иргэдээс авсан 2023 оны 2-р сарын сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс хүлээж буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын арга ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсийн үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.




СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Хүснэгт:1

Асуулт:1			
		Иргэдийн тоо	Хувь
Таны хүйс	Эрэгтэй	101	40.4%
	Эмэгтэй	149	59.6%
Нийт		250	100.0%

График:1




Дүгнэлт: Нийгмийн даатгалын хэлтсээр үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авахад 250 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 59.6% эмэгтэй, 40.4% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.



Хүснэгт:2

Асуулт:2			
		Иргэдийн тоо	Хувь
Таны нас	16-21	3	1.2%
	22-30	27	10.8%
	31-40	87	34.8%
	41-50	67	26.8%
	50-ээс дээш	66	26.4%
Нийт		250	100.0%

График:2



Дүгнэлт: Насны хувьд авч үзвэл 16-21 насны 3 даатгуулагч, 22-30 насны 27 даатгуулагч, 31-40 насны 87 даатгуулагч, 41-50 насны 67 даатгуулагч, 50-иас дээш насны 66 даатгуулагч судалгаанд хамрагдсан байна. Нийгмийн даатгалын байгууллагаар 2-р сард үйлчлүүлсэн даатгуулагчдын ихэнх хувь нь 31-40 насныхан буюу 34,8% байна.



Хүснэгт:3

Асуулт:3			
	Иргэдийн тоо	Хувь	
Та хэдэн тоотын байцаагчаас үйлчилгээ авсан бэ?	1	3	1.2%
	2	23	9.2%
	3	23	9.2%
	4	36	14.4%
	5	11	4.4%
	6	22	8.8%
	7	21	8.4%
	8	11	4.4%
	9	16	6.4%
	10	34	13.6%
Угтах үйлчилгээ	50	20%	
Нийт	250	100.0%	

График:3




Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний хэсэгт нийт 10 байцаагч, угтах үйлчилгээний ажилчид зөвлөгөө мэдээлэл үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хүргэн ажилладаг.



Хүснэгт:4

Асуулт:4			
		Иргэдийн тоо	Хувь
Та яг одоо ямар үйлчилгээ авахаар ирсэн бэ?	Тэтгэвэртэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ	70	28%
	Тэтгэмжтэй холбоотой мэдээлэл, үйлчилгээ	73	29.2%
	Эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ	30	12%
	Сайн дурын даатгалтай холбоотой мэдээлэл, үйлчилгээ	34	13.6%
	Нийгмийн даатгалын тайлантай холбоотой үйлчилгээ	17	6.8%
	Лавлагаа	7	2.8%
	Бусад	19	7.6%
	Нийт		250

График:4




Дүгнэлт: Нийт 250 даатгуулагч судалгаанд хамрагдснаас 1-р сард тэтгэмжийн даатгалтай холбоотой үйлчилгээ авахаар 57 даатгуулагч (22.8%) ирсэн бол 2-р сард 73 даатгуулагч (29.2%) болж өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Бусад даатгуулагчдын хувьд эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгал, нийгмийн даатгалын тайлан, шимтгэл төлөлтийн лавлагааны талаар мэдээлэл зөвлөгөө авахаар ирсэн байна.



Хүснэгт:5

Асуулт:5		Иргэдийн тоо	Хувь
Та үйлчилгээ авахын тулд хэдэн минут хүлээсэн бэ?	Шууд үйлчлүүлсэн	187	74.8%
	5-15 минут	47	18.8%
	15-30 минут	12	4.8%
	30 минутаас 1 цаг	3	1.2%
	1-2 цаг	1	0.4%
Нийт		250	100.0%

График:5



Дүгнэлт: Хүлээлгийн хугацааны хувьд 1-р сард даатгуулагчдын 58,4% буюу 146 даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээ авахын тулд шууд үйлчлүүлсэн бол 2-р сард 74,8% буюу 187 даатгуулагч шууд үйлчлүүлсэн байна. Энэ нь манай байгууллагын хувьд даатгуулагчдад үйлчилгээ үзүүлэхэд хүлээлгийн хугацаа дээр ямар нэгэн хүндрэл, чирэгдэлгүй илүү хурдан шуурхай үйлчилж байгаа нь харагдаж байна.



Хүснэгт:6

Асуулт:6			Иргэдийн тоо	Хувь
Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу?	Бүрэн өгч чадсан	246	98.4%	
	Хангалтгүй	3	1.2%	
	Бүрэн өгч чадаагүй	1	0.4%	
	Маш муу	0	0.0%	
Нийт		250	100.0%	

График:




Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуулгын хувьд нийт судалгаанд оролцогчдын 98.4% буюу 246 даатгуулагч “Бүрэн өгч чадсан” гэсэн хариулт өгсөн бол 1,2% буюу 3 иргэн “Хангалтгүй” байна гэсэн үнэлгээ өгсөн. 1 даатгуулагч буюу 0.4% бүрэн өгч чадаагүй гэж үнэлсэн байна.



Хүснэгт:7

Асуулт:7		
	Иргэдийн тоо	Хувь
Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ?	Маш сайн	130 52.0%
	Сайн	114 45.6%
	Дунд	5 2.0%
	Муу	1 0.4%
Нийт	250	100.0%

График:7



Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд 52% буюу 130 даатгуулагч байцаагчийн мэргэжлийн ур чадварыг “Маш сайн” гэж үнэлсэн бол 45.6% буюу 114 даатгуулагч “Сайн” гэж үнэлсэн байна. Бусад даатгуулагчдын хувьд 2.0% буюу 5 даатгуулагч “Дунд” гэж үнэлсэн ба 0.4% буюу 1 даатгуулагчийн хувьд байцаагчийн ур чадварыг маш муу гэж үнэлсэн байна.



Хүснэгт:8

Асуулт:8			
		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харьцаа, хандлагыг хэрхэн үнэлж байна вэ?	Маш өндөр ханамжтай	113	45.2%
	Сэтгэл ханамжтай	134	53.6%
	Сэтгэл ханамжгүй	3	1.2%
Нийт		250	100.0%

График:8



Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын хувьд хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултын хувьд 53.6% буюу нийт 134 даатгуулагч “Сэтгэл ханамжтай” бол 45.2% буюу 113 даатгуулагч нь “Маш өндөр ханамжтай” гэсэн хариулт өгсөн байна. Нийгмийн даатгалын хэлтсийн ажилчдын ёс зүй, зан харилцаа, хандлагад 1.2% буюу 3 даатгуулагч сэтгэл ханамжгүй гэж үнэлсэн байна.



Хүснэгт:9

Асуулт:9		
	Иргэдийн тоо	Хувь
Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ?	Маш сайн	114 45.6%
	Сайн	129 51.6%
	Дунд	6 2.4%
	Муу	1 0.4%
Нийт	250	100.0%

График:9




Дүгнэлт: Байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? гэсэн асуулгын хувьд 45.6% буюу 114 даатгуулагч сэтгэл ханамж “Маш сайн”, 51.6% буюу 129 даатгуулагч сэтгэл ханамж “Сайн” гэсэн хариулт өгсөн байна. Бусад даатгуулагчийн хувьд 2.4% буюу 6 даатгуулагч байцаагчийн үйлчилгээнд өгсөн сэтгэл ханамж “Дунд”, 0.4% буюу 1 даатгуулагч маш муу гэж хариулт тус тус өгсөн байна.



Хүснэгт:10

Асуулт:10		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ?	Маш сайн	123	49.2%
	Сайн	125	50.0%
	Дунд	2	0.8%
	Муу	0	0.0%
Нийт		250	100.0%

График:10




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээг олон дамжлагагүй 1 ажилтнаас авдаг болсныг та хэрхэн үнэлэх вэ? асуулгыг авч үзвэл даатгуулагчдын 49,2% буюу 123 даатгуулагч “Маш сайн”, 50.0% буюу 125 даатгуулагч “Сайн”, 0.8% буюу 2 даатгуулагч “Дунд” үнэлгээ өгсөн байна.



Хүснэгт:11

		Асуулт:11	
		Иргэдийн тоо	Хувь
Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ?	1 удаа	170	69.6%
	2 удаа	71	26.8%
	3-4 удаа	8	3.2%
	5-с дээш удаа	1	0.4%
Нийт		250	100.0%

График:11




Дүгнэлт: Та нийгмийн даатгалын нэг үйлчилгээ авахын тулд хэдэн удаа ирэх шаардлагатай болдог вэ? гэсэн асуултад нийт 250 даатгуулагч хамрагдснаас 1 сард 174 даатгуулагч 1 удаа ирэх шаардлага гарсан гэсэн бол 2 сард 170 даатгуулагч “1 удаа” ирэх шаардлага гарсан гэж хариулсан байна. Үүнээс харахад ихэнх даатгуулагч Нийгмийн даатгалаас үйлчилгээ авахын тулд олон дахин ирэх шаардлагагүйгээр хүссэн үйлчилгээгээ авч байгаа нь харагдаж байна.



Хүснэгт: 12

Асуулт: 12		
	Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү?	Маш сайн	65 26.0%
	Сайн	99 39.6%
	Дунд	84 33.6%
	Муу	2 0.8%
Нийт	250	100.0%

График:12




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлнэ үү? Гэсэн асуулгын хувьд үйлчилгээний ил тод нээлттэй байдлын хувьд даатгуулагчдын дийлэнхи хувь буюу 26% буюу 65 даатгуулагч “Маш сайн”, 39.4% буюу 99 даатгуулагч нийгмийн даатгалын үйлчилгээний ил тод нээлттэй байдалд “Сайн”, 33.6% буюу 84 даатгуулагч үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг үнэлэхдээ “Дунд”, 0.8% буюу 2 даатгуулагч муу гэж хариулсан байна.



Хүснэгт:13

Асуулт:13			
		Иргэдийн тоо	Хувь
Ажилтнуудын буруутай үйлдлээс болж таньд ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу?	Тийм	12	4.8%
	Үгүй	238	95.2%
Нийт		250	100.0%

График:13



Дүгнэлт: Даатгуулагчдад ямар нэгэн хүндрэл чирэгдэл учруулж, хүнд суртал гаргаж байсан эсэх асуултанд нийт даатгуулагчийн 95.2% буюу 238 даатгуулагч “үгүй” гэсэн хариулт өгсөн. Үүнээс 4.8% буюу 12 даатгуулагч дээрх асуултанд “тийм” гэсэн хариулт өгсөн байна. Даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээ авахад ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирсан нь бага байна.



Хүснэгт:14

Асуулт:14			
		Иргэдийн тоо	Хувь
Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод орчин нөхцөл, тав тухыг хэрхэн үнэлж байна вэ?	Маш сайн	56	22.4%
	Сайн	72	28.8%
	Боломжийн	102	40.8%
	Муу	20	8.0%
Нийт		250	100.0%

График:14



Дүгнэлт: Тав тух, орчин нөхцөлийн хувьд иргэд даатгуулагчдын эерэг сэтгэгдэлтэй буюу хэлтсийн зохион байгуулалт дотоод орчин нөхцөлийг 22.4% буюу 56 “Маш сайн” , 28.8% буюу 72 даатгуулагч “Сайн”, 40.8% буюу 102 даатгуулагч “Боломжийн” гэж үнэлсэн байна. Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод орчинг 1-р сард 2,8 буюу 7% даатгуулагч муу гэж үнэлсэн бол 2-р сард 8.0% буюу 20 даатгуулагч муу гэж үнэлсэн байна.



Асуулт 15. Таньд нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулах ямар нэгэн санал, хүсэлт байвал чөлөөтэй бичнэ үү?

1. Сэтгэл ханамжтай байна. Онц байлаа.
2. НДШ тухай тайлбарлаж өгч чадахгүй. 4-5 удаа явуулж байна
3. Сэтгэл ханамж өндөр байгаа
4. баярлалаа
5. харилцааны соёл сайтай байна. Ажилд нь амжилт хүсье
6. Та бүхэндээ ажлын амжилт хүсье
7. Та бүхэндээ ажлын амжилт хүсье
8. Бүгдэд амжилт хүсье. Маш шуурхай байлаа
9. Маш түргэн шуурхай байлаа. Маш гоё шуурхай ажил бүтлээ.
Баярлалаа
- 10.Онлайн үйлчилгээг сайжруулах хүсэлтэй байна.
- 11.Цаашидын ажилд нь өндөр амжилт хүсье. Баярлалаа
- 12.Байцаагч охид, хүүхнүүд зан, характер, харьцаа, ухамсар сайн байна.
- 13.Өндөр настнуудад маш хүндэтгэлтэй ханддагт баярлаж байна.
- 14.Тайлан дээр захирал, нягтлан бодогчийн нэр шууд гарч ирдэг байх
- 15.75776699 утас дуудлага авахдаа муу
- 16.Ажлаа сайн хиймээр байна.
- 17.ширээ өндөр байна
- 18.сайн үйлчилсэнд баярлалаа
- 19.баярлалаа
- 20.үйлчилгээ сайн байв
- 21.Сайн дурын даатгалын гэрээ дуусаж байгааг мессежээр мэдэгдвэл тун сайн байна.
- 22.Ер нь сайн дурын даатгал төлснөөр ямар зүйлсэд хамрагдаж болох талаар 18 наснаас доош ч юмуу тийм залуу үеийнхэндээ мэдээлэл цаг тухайд нь сайн олгох
- 23.хурдан үйлчилсэнд баярлалаа
- 24.Боломжийн байна. Хүндрэл чирэгдэл гарсангүй. Санал байхгүй.
- 25.Тэтгэвэрт гарах дөхөж байгаа тул ажилласан жил хүрсэн эсэхийг хараад зөвлөгөө өгвөл тэтгэвэр тогтоох уу. Их асуудал гардаг гэсэн. Тодорхой мэдээлэл өгөөгүй и монголиа руу ор гэсэн.утас компьютер мэдэхгүй бол хэцүү еэ тээ. Баярлалаа
- 26.Сэтгэл хангалуун байна. үйлчилгээ сайн байна. Угтах үйлчилгээний Анхмаад бас маш их талархаж байгаагаа илэрхийлье. Энэ судалгаа маш зөв байна. Баярлалаа.
- 27.Би хааяадаа ирдэг тэгэхдээ маш сайхан сэтгэл өндөр байдаг .
- 28.Сэтгэл ханамж өндөр



29. Үйлчлүүлэгчийн тав тухыг бодон үйлчлүүлэхдээ сандалтай болвол дээр байх. Жич: өвчтэй, өндөр настан, жирэмсэн гээд хүмүүст тухтай.
30. Амжилт хүсье
31. Боломжийн
32. 7 номерын эгч таньд баярлалаа. Үнэхээр сайн шүү.
33. Очер дугаар авдаг машинаа ажилд оруулж үйлчилвэл сайн байна.
34. Сэтгэл ханамжтай байна.
35. Асуусан ажлаа амжуулж авсан.

Эерэг сэтгэл-25

Сөрөг сэтгэгдэл- 3

Бусад- 7

16. Байцаагчийн буруутай үйлдлээс болж ямар нэгэн хүндрэл, чирэгдэл учирч байсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:

График:16



Дүгнэлт: Дээрх графикаас харахад ажилтны буруутай үйлдлээс болж хүндрэл, чирэгдэл учирдаг нь бага харагдаж байна.



17. Байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагын үнэлэмжийн хувьд дараах үзүүлэлттэй байна:


График:17



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа 7 номертой байцаагчийн үйлчилгээнд дунд 1, 5 номертой байцаагчийн үйлчилгээнд 1 даатгуулагч муу гэж хариулсан бол бусад байцаагчийн хувьд үйлчилгээ авч буй даатгуулагчид маш өндөр сэтгэл ханамжтай, сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.

18. Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултыг авч үзэхэд:

График:18




Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуултын хувьд 4 дугаартай



байцаагчийн хувьд 35 даатгуулагч хүссэн мэдээллийг бүрэн өгч чадсан бол 1 даатгуулагч дунд гэж үнэлгээ өгсөн байна. Мөн 10 дугаартай байцаагчаас үйлчилгээ авч буй иргэдийн хувьд 34 даатгуулагчдад мэдээлэл бүрэн өгч чадсан гэж хаирулсан байна.

19. Байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултыг авч үзэхэд:


График:19



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа байцаагчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхдээ 10 дугаартай байцаагчийн хувьд 22 даатгуулагч маш сайн, 11 даатгуулагч сайн гэж үнэлсэн бол 4 дугаартай байцаагчийн мэргэжлийн ур чадварыг үнэлэхдээ 20 даатгуулагч маш сайн, 16 даатгуулагч сайн гэж үнэлсэн байна.

20. Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулт дараах үзүүлэлттэй байна.

График:20



Дүгнэлт: Нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэдийн байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд 4 дугаартай




байцаагчаас үйлчилгээ авч байгаа 20 даатгуулагч маш сайн, 16 даатгуулагч сэтгэл ханамж сайн гэж хариулсан байна. 10 дугаартай байцаагчийн үйлчилгээнд 14 даатгуулагч сэтгэл ханамж маш сайн 18 даатгуулагч сайн гэж үнэлсэн байна. Үүнээс үзэхэд нийгмийн даатгалын үйлчилгээг авч буй иргэдийн хувьд үйлчилгээнд сэтгэл ханамжтай байна.

Сэтгэл ханамжийн индексийн үнэлгээ:

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлүүлэхдээ 1-10 гэсэн Лайкертын шкал (хэмжүүр) ашигласан болно. Уг индексийн агуулгын хувьд 9.00-10.00 байвал хэрэглэгч маш сэтгэл ханамжтай бөгөөд энэ нь бодит нөхцөл байдал дээр тийм ч олон тохиолддоггүй онолын түвшиний ойлголт юм. 8.00- 8.99 хооронд тохиолдолд сэтгэл ханамжтай ба байгууллагууд энэ түвшинд байхад харьцангуй санаа зовох зүйл бага байдаг. Харин 6.00-8.00 хооронд хэрэглэгчийн сэтгэл ханамж дээгүүр түвшинд байгаа бөгөөд цаашид нэмэгдүүлэх шаардлагатайг илэрхийлсэн мэдээлэл юм. Харин 5.99-өөс доош байгаа бол энэ


Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Та байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хэрхэн үнэлэх вэ? гэсэн асуултад 1-р сард 5 дугаартай байцаагч 9.58 үнэлгээ авсан бол 2-р сард 8.18 болж буурсан байна. Харин 10 дугаартай байцаагч 1-р сард 8.45 байсан бол 2-р сард 9.04 үнэлгээтэй болж өссөн үзүүлэлттэй байна. Ихэнх байцаагчийн хувьд 2-р сард индекс нь буурсан үзүүлэлттэй харагдаж байна.




Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Тухайн байцаагч таны хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан уу? Гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 1-р сард 3, 5, 7, 8 дугаартай байцаагч нар 10.0 үнэлгээтэй байсан бол 2-р сард 2, 3, 6, 7, 8, 9, 10 дугаартай байцаагч нар 10.0 үнэлгээтэй байна. Үүнээс үзэхэд ихэнх байцаагчийн хувьд иргэдэд хүссэн мэдээллийг бүрэн гүйцэд өгч чадсан байна.


Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Үйлчилгээ авсан байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг та хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 1-р сард 5 дугаартай байцаагчийн ёс зүй, харилцаа, хандлага 9.58 байсан бол 2-р сард 7.95 болж буурсан үзүүлэлттэй байна. Харин 6 дугаартай байцаагч 1-р сард 8.13 байсан бол 2-р сард 8,86 болж өссөн үзүүлэлттэй байна.




Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал:



Дүгнэлт: Та байцаагчийн үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байна вэ? гэсэн асуулгын хувьд байцаагч тус бүрээр индекслэн харьцуулвал 1-р сард дугаартай байцаагчийн хувьд 9.62 байсан бол 2-р сард 7,66 болж буурсан үзүүлэлттэй байна. Харин 6 дугаартай байцаагч 1-р сард 8.13 байсан бол 2-сард 8,86 болж өссөн үзүүлэлттэй байна. Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсийн 2 сарын үйлчилгээ, орчин нөхцлийг үнэлэх судалгааны 10-н асуултыг индекслэхэд **8.62** байна.



Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний дундаж индекс 1, 2 сар харьцуулалт



Судалгааны нэгтгэл хийсэн: Н.Оюун-Эрдэнэ/...../